

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэдэндорж	Дугаар	L330
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Уянга сум
Төрсөн газар	Уянга сум	Төрсөн он	1908
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уянгын хүрээ буюу Сайн ноёны хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХУЯ 027
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Уянга сумын Уянгын хүрээ

Жужа: Баруун дацан хэдэн ламтай вэ?

Цэдэндорж: Ер нь 1000 шахуу лам байсан байх шүү. Уянгын хүрээ чнь 3000 гаруй лам нартай байсан юм уу даа.

Жужа: Дуганууд юугаар хийсэн дуган байсан бэ?

Цэдэндорж: Дуган нь хадаас энэ тэр байхгүй, дандаа сийлээд заагаад хийчихсэн. Түүний бөгстэй, дээшээ модоор хийсэн. Зарим дуганууд нь наалантай байсан юм.

Жужа: Уянгын хүрээний гол шүтээн сахиус ямар сахиус байсан бэ?

Цэдэндорж: Барууны сахиус бол улаан сахиус л гол шүтээн нь байсан юм, олон бурхантай. Ганцхан хаалгатай тэр хаалгаар орохоор суумал, шүүмал бурхан зөндөө байдаг байсан.

Жужа: Уянгын хүрээнд хадгалсан шүтээн байна уу?

Цэдэндорж: Тус тусдаа шүтээнтэй, чойр бол ногоон дарь эх шүтдэг байсан.

Жужа: Гавжийн дамжаа байсан уу?

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Яг хэзээ цам гардаг байсан бэ?

Цэдэндорж: Майдрын өмнө цам гардаг байсан.Зуны адаг сарын шинийн 8-нд эргэдэг байсан юм, майдр эргэдэг басйан.

Жужа: Хэдэн баг гардаг байсан бэ?

Цэдэндорж: Өө олон байсан. Тэр их олон бурхнуудын багийг өмсөөд л , зүүлтүүд нь шажигнаад л их сайхан байдаг байсан. Арван хангал, цам махгал, улаан сахиус цугаараа гардаг байсан.

Жужа: Шанага гэж гардаг байсан уу, хар малгайтай?

Цэдэндорж: Цэнхэр малгай л хааяа томчууд өмсдөг байсан юм.

Жужа: Ганжуур эргэдэг байсан уу?

Цэдэндорж: Эргэдэг байсан. Хүрэн дотроо ч эргэдэг байсан.

Жужа: Жил болгон уу?

Цэдэндорж: Зарим жил амардаг байсан байх.

Жужа: Хайлан хурдаг байсан уу?

Цэдэндорж: Хурж байсан.Майдрын дараа хурж байсан байх шүү.

Жужа: Хаана аль дуганд хурж байсан бэ?

Цэдэндорж: Цогчин дуганд хурж байсан байх.

Жужа: Ойролцоогоор хэдэн лам хурдаг байсан бэ, хайланд?

Цэдэндорж: Хэд я байж магадгүй ш дээ, 100 ч байж магайдгүй, 50 ч байж магадгүй.

Жужа: Сайн ноён хан хүрээнд суудаг байсан уу?

Цэдэндорж: Тэгсэн.

Жужа: Өргөө нь хаана байсан?

Цэдэндорж: намайг сууж байхад бол байгаагүй. Шарилыг нь аваачаад шарилын магнай гэдэг ууланд тавьсан гэдэг байсан.

Жужа: Ямар газар?

Цэдэндорж: Шарилын магнай гэдэг газар.

Жужа: Таны тэр үед хүрээг толгойлох лам хэн байсан бэ?

Цэдэндорж: Чойр хамбатай байсан, цогчин хамбатай байсан. Тэр хамбануудыг чинь би танихгүй. Нэг тийм шовгордуу шар малгайг чинь , шомбогор шовх оройтой тийм шовх малгатай байсан. Залатай.

Жужа: Уянгын хүрээ хэдэн онд хаагдсан бэ?

Цэдэндорж: 1937 оны өвөл.

Жужа: Та тэр хүртэл тэнд суудаг байсан уу?

Цэдэндорж: Хүрээ тарахаас өмнө би хөдөө гарчихсан байсан.

Жужа: Хэдэн он хүртэл суусан бэ?

Цэдэндорж: Би 16-тай л гарч байсан юм даг, хүрээндээ.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

3

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэдэндорж: Байсан, аранжамбын дамжаа байсан.томчууд , эрдэмтэн номтой үлсүүд л гавж, аграмжийн дамжаа хийж байлаа шүү дээ.

Жужа: Ямар ямар алдартай хутагт хувилгаан байсан бэ?

Цэдэндорж: Төвдөөг шашны том төлөөлөгч л байсан юм даа. Гачин ламыг нь би одоо мэдэхгүй юм даа.

Жужа: Өөр хутагт хувилгаан?

Цэдэндорж: Их олон байсан юм. Тэрний тоог би яаж мэдэхэв.

Жужа: Ямар ямар дуганууд байсан бэ?

Цэдэндорж: Олон байсан юм, Баруун дуган, чойр дуган, жанчивлин дуган, дүйнхор дуган, голын дуган тэгээд нэлээн олон байсан. Зөвхөн том дуган нь 30 гаруй байсан. Тоолж мэдэхгүй.

Жужа: Жүд дацан байсан уу?

Цэдэндорж: Байсан, мамба дацан байсан. Чойр дацан бол одоо гүрэм дом нэг их тийм юмнууд заадаг байсан шүү. Чойрын онилгыг жигтэйхэн үзэж байсан.

Жужа: Зоч лам нар байсан уу? Лүйжин тавьдаг?

Цэдэндорж: Байсан, би таньдаггүй.

Жужа: Хандмаа, эмэгтэй лам нар байсан уу?

Цэдэндорж: Байгаагүй байх аа, мэдэхгүй байна.

Жужа: Суварга байсан уу?

Цэдэндорж: Суварга их олон байсан. Тойроод ч , хажууд нь ч .Олон сүм байсан. Сүмийнх нь тоо ч алга.

Энхбаяр: Бааюу байсан л байлгүй?

Цэдэндорж: Хүрээний урд талд нэг толгой дээр бааюу байсан. Хятадууд л байсан. Тэгээд хятадууд ч тэрүүгээр явж л байдаг байсан. Шохой хийгээд л , би харж л байсан. , Бараан цэмбэн үстэй дээлтэй ташууртай, хятадууд нь тэгээд л...Тэнд л бааюу гээд байна даа. Уянгын хүрээг одоо бараагаар хангадаг, нөгөө талаар түүнийгаар хангадаг байсан байгаа юм. Тэр барилгыг ч хятадууд барьсан. Дандаа дөрвөлжин, тэгээд л орой дээрээ тоононоос том тийм алтан хорол, тэр хоёр талд нь 2 шар гөрөөс байдаг байсан. Том оо, тэгээд дотроо алтан ганжир орой дээрээ их том алтан ганжир байсан юм. Тэгээд тэр хуралд орохоороо тэр цаг цагаар хуваарлиж байсан юм.

Жужа: Уянгын хүрээ хэдэн аймагтай байсан бэ?

Цэдэндорж: Тэр дацан гэж ярина уу гэхээс аймаг гэж байгаагүй.

Жужа: Лам нар хаана хаана суудаг байсан бэ?

Цэдэндорж: Хүрэн дотроо л байшинтай, гэртээ суудаг байсан.

Жужа: Хэдэн жастай байсан бэ?

Цэдэндорж: Тэр хурал хурдаг хүрээ болгон жастай байсан. Их олон малтай, адуутай.

Жужа: Цам бүжигтэй байсан уу?

Цэдэндорж: Цам гаралгүй яхав, сор залдаг байсан, хорин есөнд. Майдр эргэдэг байсан.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хар болоод тэгээд юу юу хийсэн бэ?

Цэдэндорж: мал л малласан даа. 19 настай ардын цэрэгт явсан.

Жужа: Хэдэн жилийн хугацаагаар?

Цэдэндорж: 6 жилийн хугацаагаар, Халх голын дайн, тэгээд л дараа нь дэлхийн 2-р дайн гээд л ...

Жужа: Уянга сумын төвд байгаа шинэ хийдийн талаар?

Цэдэндорж: Тэр цогчин хуралтай тийм...

Жужа: Тэнд хурдаг уу, өөрөө?

Цэдэндорж: Хурдаг аа, энэ жил бие чадаагүй.

Жужа: Уянгын хүрээний өөр настай лам байсан уу?

Цэдэндорж: Хоёр лам байдаг юм. Нэгэнд нь би ордог юм. Энэ Баянтээлд нэг бас лам байдаг юм. Хийд сэргэж байхад 30 гаруй лам байсан. Тэрнээс нэг хоёр гурав л үлдсэн байх аа.

Жужа: Уянга суманд өөр сүм хийд байсан уу?

Цэдэндорж: Энэ хавьд олон сүм хийд байсан юм билээ. Энэ барууханд Олон хийд гэж байсан юм.

Энхбаяр: Та тэр хийдийн тухай мэдэх юм байвал хэлээ?

Цэдэндорж: Тэрийг би мэдэхгүй. Доошоо газарт шигдээд орчихсон, жаахан ухаж харахаар бол дандаа хөх түүнийгаар барьчихсан. Өвгөн хийд гэдэг юм.Хоёр шавар л байх юм билээ.

Жужа: Өвгөн хийдэд хэдэн лам байсан, мэдэх үү?

Цэдэндорж: Мэдэхгүй, очиж үзээгүй.Ямар сайндаа хоёр шавар байх юм билээ л гэж сүүх билээ.Мод зоорь энэ тэр байсан юм билээ л дээ.

Жужа: Тэр Уулшхайн хийдийн талаар мэдэх юм байна уу?

Цэдэндорж: Уулшхайгаар хальт дайраад өнгөрч л байсан. Нэг их очиж байгаагүй, Уулшхай чинь хүний дүрстэй том чулуу юм шүү дээ. Тогтмол хуралтай, ямар ном уншиж байсныг нь мэдэхгүй. Ганцхан сүм байсан юм, дуган гэдэг чинь томыг нь хэлдэг юм. Сүм гэдэг чинь жижигийг нь хэлдэг юм. Хоёр л лам байсан байх. Мөнх зултай.

Жужа: Жас хүүгийн рашааны талаар сонссон уу?

Цэдэндорж: Сонссон.

Жужа: Тэнд бас сүм байсан уу?

Цэдэндорж: Жаахан нэг ном судраа хийдэг шомбогор сүм байсан юм. Тэрийг нураагаад хаячихсан юм, тохуурхаж байсан биз. Тэгээд л нэг хүн зул хүржийг нь асаадаг

Жужа: Тогтмол хурал байсан уу?

Цэдэндорж: Тогтмол хурал байгаагүй. Тэр Рашаанд орсон хүмүүс л зулыг нь барьж, өвөл хавар рашаанд орохгүй шүү дээ. Тэр араараа тойроод Бат-Өлзийн төв орж байгаад араар өгсөөд шүүд машин хүрэхгүй, мориор юм уу явгаанаар очдог юм.

Жужа: Зүүн, Баруун Өрөөтийн хийдийн талаар?

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

4

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэдэндорж: Өрөөт гэж байсан юм. 20, 30-аад лам нартай байсан байх. Нэг л дугантай байсан юм. Баруун, зүүн Өрөөт гэж байсан юм. Хүрээнд ойрхон тийм байсан.

Жужа: Зүүн Өрөөт, Уулшхай нэг хийдийн хоёр нэр үү үгүй юу?

Цэдэндорж: Үгүй, тусдаа. Өрөөт чинь сүүлд дэлгэрсэн юм.

Жужа: Зүүн, баруун Өрөөт хүрээнээс аль тийшээ байна вэ?

Цэдэндорж: Баруун Өрөөт чинь баруун тийшээ байсан юм. Уулшхай чинь хүрээнээс баруун өмнө байсан юм. Зүүн Өрөөтийн байсан газрыг би мэдэхгүй.

Жужа: Хүрээний эргэн тойронд ямар ямар тахилгат овоо байсан?

Цэдэндорж: Хан хөгшнийг л тахидаг байсан юм гэнэ лээ. Хүрээнээс баруун тийш.

Жужа: Өөр овоо байсан үү?

Цэдэндорж: Хойшоо Баян-Уул гэж өндөр үүл бий.

Жужа: Таны сууж байсан баруун дацанд хэдэн гэсгүй байсан бэ, цорж үнзэд гэх мэт?

Цэдэндорж: Үнзэд хэд хэд байсан юм. Жинхэнэ үнзэд, бага үнзэд нэг 7, 8 байшинтай. Жинхэнэ үнзэдийн туслах үнзэдыг нь агь үнзэд гэж байгаа юм даа. Дуган бүр үнзэдтэй байсан. Чойр, дүйнхор гээд л дандаа гэсгүйтэй. Бүх хүрээг хариуцсан даа лам, дэм лам гэж хоёр том лам байсан.

Жужа: Ловон лам байсан үү?

Цэдэндорж: Ловон байлогүй яахав, бүх дуган ловонтой байсан байх аа.

Жужа: Цорж лам байсан үү?

Цэдэндорж: Байсан.

Жужа: Баруун дацанд ямар ямар хурал хурдаг байсан бэ?

Цэдэндорж: Арван хангал ч хурдаг байсан, тэгээд л чойжид энэ тэрийг хурдаг байсан.

Жужа: Ямар ямар шүтээн байсан бэ?

Цэдэндорж: Баруун дацанд чинь олон байсан. Арван хангалаас өгсүүлээд л, цагаан дарь эх, хорин нэгэн дарь эх гээд л их олон байсан. Тоолохын аргагүй.

Энхбаяр: Дом тавьдаг байсан үү?

Цэдэндорж: Домын дамжаа бариад л дом тавьдаг байсан.

Жужа: Ламиран дацан байсан үү?

Цэдэндорж: Байсан.

Жужа: Ламиран дацангийн дэргэд ямар дуган байсан бэ?

Цэдэндорж: Ламиран чинь дугантай байсан шүү дээ.

Жужа: Цогчин дуган яаж харагддаг байсан бэ, хэдэн давхар байсан бэ?

Цэдэндорж: Цогчин дуган хамгийн өвгөн дуган нь байсан юм. Шалаар нь доогуурх лам нар нь харагдаж байдаг, бараг. Мод нь элэгдээд цооорчихсон. Дээд өрөө нь олон тасалгаатай. Баруун дуган болвол баруун талдаа жижигхэн бас өрөө байдаг байсан юм. Тэрүүнд нь жасаа хурдаг байсан юм. Төвд маягийн л дуган байсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Бархан, ном барлах газар байсан үү?

Цэдэндорж: Байсан, тусдаа тийм жижиг өрөөтэй. Ном барлаж байдаг.

Жужа: Мянган дуутын сүм гэж байсан үү?

Цэдэндорж: Мянган бурхны сүм гэж байсан. Мянган дуутын сүм гэж байгаагүй.

Жужа: Тэнд бурхан багш байсан үү?

Цэдэндорж: Байлгүй яахав.

Энхбаяр: Таньд одоо өөр сайхан түүх юм байвал ярьж өгөөч?

Цэдэндорж: Түүх гэвэл за одоо өөр юу ч ярихав дээ. Дуган сүм бол их гоё байсан, ямар сайндаа дээвэр нь хүртэл паалантай байхав дээ.

Жужа: За болсон. Их баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон